

АРХАНГАЙ АЙМГИЙН УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
Стратеги төлөвлөгөөний зорилт 1, Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт							
“Архангай аймгийн тогтвортой хөгжлийн хэтийн зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөө -2026” бодлогын баримт бичгийн-Зорилт 6-ын 6.2 дахь заалт, Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр							
1.	Зорилт 1. Ус, цаг уур, байгаль орчны хяналт шинжилгээний улсын сүлжээний хэвийн үйл ажиллагаа, хэмжлийн нэгдмэл байдлыг хангах, техник, технологийн шинэчлэл хийх, ажиллах нөхцөлийг сайжруулах	Улсын төсөв, гадаадын зээл тусламж	Шинэ барилгатай болсон харуулын тоо	2025 онд БОУАӨЯ-ны хөрөнгө оруулалтаар Эрдэнэмандал болон Төвшрүүлэх сумдын цаг уурын өртөөнд шинээр пассив барилга баригдаж ашиглалтад орсон.	1	2026 оны төсөвт Урд тамир ус судлалын харуулын барилгын төсөв батлагдсан бөгөөд гүйцэтгэгч компанид тус барилгыг барих газрын гэрчилгээ, кадастрын зургийг хүргүүлсэн.	100%
2.	Арга хэмжээ 1.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Урдтамир усны харуулын байрыг шинээр ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулах	Улсын төсөв, гадаадын зээл тусламж	-Ажлын гүйцэтгэл, %	0	100	2026 оны төсөвт Урд тамир ус судлалын харуулын барилгын төсөв батлагдсан бөгөөд гүйцэтгэгч компанид тус барилгыг барих газрын гэрчилгээ, кадастрын зургийг хүргүүлсэн.	100%
3.	Арга хэмжээ 1.2. Агаарын чанарын хяналт-шинжилгээний сүлжээг өргөтгөх хөтөлбөр хэрэгжүүлнэ.	Улсын төсөв, гадаадын зээл тусламж	PM10 тоосонцор хэмжигч багаж суурилуулсан тоо	-	1	2026 оны 3 дугаар улиралд PM10 тоосонцор хэмжигч багаж суурилуулах ажил хийгдэнэ.	100%

1	2	3	4	5	6	7	8
Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт Улсын Их Хурлын 2024 оны 46 дугаар тогтоол, Засгийн газрын 2013 оны 10 дугаар тогтоол “Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх журам”, Засгийн газрын 2015 оны 286 дугаар тогтоол, Стратеги төлөвлөгөөний зорилт 2, 4, 5 ЦУОШГ, ИНЕГ-ын даргын 2011 оны хамтарсан А/450/167 дугаар тушаалаар баталсан “Цаг агаарт зориудаар нөлөөлөх үед агаарын хөлгийн нислэгийн аюулгүй байдлыг хангах” журам, “Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны заавар”, Цаг агаарын урьдчилсан мэдээ, Цаг агаарын аюултай үзэгдлээс сэрэмжлүүлэх, урьдчилан сэргийлэх, мэдээллийг төв, орон нутагтай уялдуулан урьдчилан мэдээлэх, салбарын хэмжээнд нэгэн утгатайгаар гаргах.							
4.	Зорилт 2. Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг зохион байгуулах	Улсын төсөв, орон нутгийн төсөв	-Удирдлага зохион байгуулалт, бэлэн байдлын хангалт, -Заавар, технологи мөрдөлт, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, -Ажлын дүн, хувь	ЦУОШГ-ын даргын 2025 оны 03 сарын 10-ны өдөр А/263 тушаалын дагуу Эрдэнэмандал, Цэцэрлэг, Хайрхан, Өлзийт сумын нутгаар цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа явуулсан. Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны акт болон коод мэдээг тухай бүр цаг хугацаанд Цаг уур, орчны шинжилгээний газарт хүргүүлсэн. Ажлын дүн 93.7%	Ажлын дүн 94.0%	ЦУОШГ-ын даргын 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдөр А/57 тушаалын дагуу сумдаас ирүүлсэн захиалгаар 04 сарын 07-08-нд Эрдэнэмандал, Цэцэрлэг, 04 сарын 29-нд. Жаргалант, Эрдэнэмандал, 05 сарын 13-нд Цэцэрлэг Хайрхан, Өлзийт, 05 сарын 16-нд Цахир, 05 сарын 21-нд Өгийнуур, 22нд Хашаат сумдын нутгаар тус тус цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа явуулсан. Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны акт болон код мэдээг тухай бүр цаг хугацаанд Цаг уур, орчны шинжилгээний газарт хүргүүлсэн.	100%
5.	Арга хэмжээ 2.1. Цаг агаарт зориудаар нөлөөлөх техник хэрэгслийн аюулгүй байдал, хангалтыг сайжруулах	Улсын төсөв, орон нутгийн төсөв	-Шинээр авсан пуужингийн тоо	2025 онд шинээр 30ш пуужин авсан. Үлдэгдэл пуужин 7ш.	20 ш пуужин авна.	Цаг уур, орчны шинжилгээний газраас 2026 оны 03 дугаар сард 20 ш пуужинг татан авч пуужингийн нөөцийг нэмэгдүүлсэн.	100%
6.	Арга хэмжээ 2.2. Сум, орон нутгийн тусгай захиалгаар цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаа явуулах.	Орон нутгийн төсөв	-Гүйцэтгэл, %	-Цахир, Өндөр-Улаан Эрдэнэмандал, Хайрхан, Өлзийт зэрэг 5 сум -Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл	Гүйцэтгэл 100%	-Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг 5 удаа явуулсан. Үүнд: -Эрдэнэмандал-2удаа, 4ш пуужин -Цэцэрлэг-2удаа 5ш+2ш пуужин -Жаргалант-1 удаа, 2ш пуужин	100%

1	2	3	4	5	6	7	8
				ажиллагааг 6 удаа явуулсан. Гүйцэтгэл 100%		-Өлзийт-1 удаа ,2ш пуужин - Хайрхан1 удаа ,2ш пуужин, - Цахир 1 удаа ,3ш пуужин -Хашаат 1 удаа , 2ш пуужин -Өгийнуур 1 дуаа 2ш пуужин нийт 24ш пуужин зарцуулсан.	
7.	Арга хэмжээ 2.3. Хуурайшилтын зэргийн үнэлгээ хийж аймгийн Онцгой байдлын газрыг мэдээллээр хангах	Улсын төсөв, орон нутгин төсөв	-Мэдээний тоо	Хуурайшилтын зэргийг 214 мэдээ гаргаж үйлчилсэн.	Мэдээний тоо 214	Архангай аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 2026 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс 05 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хуурайшилтын зэргийг 72 удаа бодож, 7 хоног бүрийн Даваа гарагт тархалтын зураглалыг боловсруулж аймгийн Онцгой байдлын газарт нийт 10 удаа мэдээгээр үйлчилсэн.	100%
9.	Арга хэмжээ 2.4. Цаг агаарт зориудаар нөлөөлөх ажлын гүйцэтгэлийн үр дүнгийн тайлан гаргах.	Улсын төсөв	-Ажлын дүн,%	Ажлын дүн 93.7%	Ажлын дүн 94.0%	04, 05 дугаар сарын цаг агаарт зориудаар нөлөөлсөн үйл ажиллагааны тайланг гаргаж ftp://192.168.110.30/ хаягаар хүргүүлэв.	100%
10.	Зорилт 3. Цаг агаарын урьдчилсан мэдээний таарцыг дээшлүүлэх	Улсын төсөв	-Нарийвчилсан, 1 болон 5 хоногийн урьдчилсан мэдээний таарц, % Дээрх урьдчилсан мэдээнүүдийн Дундаж таарц, %	Сүүлийн 3 жилийн Урьдчилсан мэдээний дундаж 96.0%	Урьдчилсан мэдээний Дундаж таарц 96.5 %	06 дугаар сарын 05-ний байдлаар: Дундаж таарц 97.7% Ирц 100%	100%
11.	Арга хэмжээ 3.1. Цаг агаарын урьдчилсан мэдээгээр үйлчлэх.	Улсын төсөв	Урьдчилсан мэдээнүүдийн дундаж Таарц ,%	Дундаж таарц 96.0%	Дундаж таарц 96.5%	05 дугаар сарын 31-ний байдлаар 151 удаа үйлчилсэн. Дундаж таарц -97.8%	100%
12.	Арга хэмжээ 3.2. Орон нутагт үйлдэгдэх	Улсын төсөв	Нислэгт үйлчилсэн цаг	Цаг агаар мэдээгээр үйлчилсэн мэдээний	Мэдээний чанар 100% .	2026 оны 05 дугаар сарын 31-	97.05

1	2	3	4	5	6	7	8
	нислэгт цаг уурын мэдээгээр үйлчлэх		агаарын мэдээний чанар,%	чанар 100%		ний өдөр хүртэл орон нутагт 7 нислэг үйлдэгдсэн. Мэдээний чанар 100%. мэдээ зохиолт чанар 91,0%	
13.	Арга хэмжээ 3.3. Аюул, агаар, климат мэдээ дамжуулалтын чанарыг сайжруулах.	Улсын төсөв	Мэдээний ирц,% Чанар ,% Дээрх үзүүлэлтийн Дундаж , % 2	Дундаж 99.9%	Дундаж 100%	Аюул агаар мэдээ 574, сарын климат мэдээ 6 удаа, 10 хоногийн климат мэдээ 15 удаа Ирц 100% Чанар 99.8% Дундаж 99.9%	100%
14.	Арга хэмжээ 3.4. Цаг агаарын тойм мэдээг гаргаж олон нийтэд үйлчлэх.	Улсын төсөв	-Мэдээлэл хүргэсэн сувгийн тоо -Гаргасан мэдээний төрөл, тоо -Гаргасан мэдээ, тоо	Мэдээлэл хүргэсэн сувгийн тоо-4 Гаргасан мэдээний төрөл-2 Гаргасан мэдээ-429	Мэдээлэл хүргэх сувгийн тоо-4 Гаргах мэдээний төрөл-2 Гаргах мэдээ-429	Цаг агаарын 1 хоногийн тойм мэдээ 151, 7 хоногийн тойм мэдээ 21 удаа тус тус гаргаж холбогдох сайтуудад байршуулж үйлчилсэн. Архангай цаг уур facebook болон Page хуудас, https://arkhangai.weather.gov.mn /-д байршуулан үйлчилсэн.. (https://arkhangai.weather.gov.mn /-д байршуулсан мэдээ мэдээлэл Arkhangai namem.gov.mn болон gov.mn сайтад) линкээр холбогдон тавигдаж байна.	100%
15.	Зорилт 4. Мэдээлэл солилцооны ажлын чанарыг сайжруулах.	Улсын төсөв	Мэдээ дамжуулалтын чанар, % Мэдээ солилцооны чанар, % Сүлжээ ашиглалт,% Тоног төхөөрөмжийн бэлэн байдал,	Сүүлийн 3 жилийн дундаж 99.9%	Дундаж 99.9%	Цаг уурын 4 өртөө, Хөдөө аж ахуйн цаг уурын 13 харуул, мэдээнүүдэд сүлжээнээс шалтгаалсан мэдээний хоцрогдол, тасалдал, гэмтэл саатал гараагүй. Мэдээ дамжуулалтын чанар 99.9% Мэдээ солилцооны чанар 100%	100%

1	2	3	4	5	6	7	8
			% Эдгээр үзүүлэлтийн дундаж, %			Сүлжээ ашиглалт, 100% Тоног төхөөрөмжийн бэлэн байдал, 100% Дундаж 100%	
16.	Арга хэмжээ 4.1. Өртөө, харуулын ажиглалтын мэдээ дамжуулалтын чанарыг сайжруулах.	Улсын төсөв	Мэдээ дамжуулалтын чанар, %	Сүүлийн 3 жилийн дундаж Мэдээ дамжуулалтын чанар 86.0%	Мэдээ дамжуулалтын чанар 90%	Мэдээ дамжуулалтын чанар 99.9%	99.9%
17.	Арга хэмжээ 4.2. Байгууллагын тоног төхөөрөмжийн тасралтгүй, хэвийн ажиллагааг хангах.	Улсын төсөв	-Сүлжээ ашиглалт, % -Тоног төхөөрөмжийн бэлэн байдал, % Дээрх 2 үзүүлэлтийн дундаж дүн %	Дундаж дүн 99.9%	Дундаж дүн 99.9%	2026 оны 06 дугаар сарын 04-ний байдлаар Төвшрүүлэх өртөө-1 компьютер, Хяналтын камер-1, Урьдчилан мэдээлэхийн -1, Ус судлалын -1, ЦУ, ХААЦУ техникч, инженер-2, ЦАЗН-1, БОШЛ-1 компьютерүүдэд, болон тоног төхөөрөмжид (нийт 8) засвар үйлчилгээ хийсэн. Мэдээ дамжуулалтын чанар, 99.9% Мэдээ солилцооны чанар, 100% Дундаж 100%	100%
18.	Зорилт 5. Ус цаг уур, орчны шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх.	Улсын төсөв	Шинжилгээний ажлыг дүгнэх журмын дагуу хувиар үнэлнэ. Шинжилгээний ажлын дундаж дүн, %	Ус, цаг уур, орчны шинжилгээний салбар (ГУС, ХААЦУ, ЦУУА, багаж хэмжил зүй, АМДС, БОШЛ)-ын шинжилгээний ажлын дундаж дүн сүүлийн 3 жилийн дундаж дүн 99.4%	Дундаж дүн 99.4%	-Ус цаг уур, орчны шинжилгээний хөтөлбөрт ажил хэрэгжиж байна. 06 дугаар сарын 04-ний байдлаар шинжилгээний ажлын дундаж дүн 99.7% байна. Дундаж 99.7%	100%
19.	Арга хэмжээ 5.1. Цаг уурын шинжилгээний ажлыг хөтөлбөрийг хэрэгжүүлэх.	Улсын төсөв	Ажлалтын чанар, Шүүмжийн чанар	Дундаж үзүүлэлт 99.0%	Дундаж үзүүлэлт 99.0%	Цаг уурын шинжилгээний ажлын дүн 2026 оны 06 дугаар сарын 04-ний байдлаар ажиглалтын чанар 98.6%, шүүмжийн чанар 99.6%, дундаж үзүүлэлт 99.1%-тай байна.	100%

1	2	3	4	5	6	7	8
			үзүүлэлтийн дунджаар дүгнэнэ. Дундаж үзүүлэлт, %				
20.	Арга хэмжээ 5.2. Хөдөө аж ахуйн цаг уурын шинжилгээний ажлыг хөтөлбөрийг хэрэгжүүлэх.	Улсын төсөв	Мэдээний ирц, Хөтөлбөрийн биелэлт, Ажиглалтын мэдээний бүтэц, ажиглалтын мэдээний чанар, Шүүмж шалгалт дундаж дүн %	Сүүлийн 3 жилийн дундаж дүн 99.7 %	Дундаж дүн 100%	06 дугаар сарын 04-ний байдлаар Агро дундаж мэдээний ирц 100%, хөтөлбөрийн биелэлт 100%, ажиглалтын мэдээний бүтэц 100% ажиглалтын мэдээний чанар 100%, шүүмж шалгалт-100%, Шинжилгээний ажлын дундаж дүн: 100%	100
21.	Арга хэмжээ 5.3. Өвлийн бэлчээрийн явуул судалгааг хийх ажлыг зохион байгуулах.	Улсын төсөв, орон нутгийн төсөв	Судалгаа хийгдсэн сум, багийн тоо	Аймгийн 19 сумын 101 багт өвлийн бэлчээрийн судалгааг мониторингийн 101 цэгт хийж өвөлжилтийн байдлыг тодорхойлсон.	Аймгийн 19 сумын 101 багт өвлийн бэлчээрийн судалгааг мониторингийн 88 цэгт хийж, цасны зурган болон өвөлжилтийн байдлыг тодорхойлно.	2026 оны 1 дүгээр сарын 3 дугаар 10 хоногт Аймгийн 17 сумын 88 багт өвлийн бэлчээрийн судалгааг мониторингийн 88 цэгт хийж, цасны болон өвөлжилтийн байдлыг тодорхойлж иргэдэд үйлчилсэн.Эрдэнэмандал, Их-Тамир сумдын нутгаар нийт нутгийн 60 хүртэлх хувьд цасан бүрхүүл тогтоогүй байсан учир зааврын дагуу явуул судалгааг хийгээгүй.	100
22.	Арга хэмжээ 5.4. Бэлчээрийн төлөв байдлын ажиглалт, судалгааг хийж, 2026-2027 оны өвөл, хаврын бэлчээрийн даацыг тодорхойлох ажлыг зохион байгуулах.	Улсын төсөв, орон нутгийн төсөв	Хамрагдсан сумын тоо	19 сум	19 сум	Жил бүрийн 08 дугаар сарын 2 дугаар 1 хоногт бэлчээрийн төлөв байдлын ажиглалтыг 19 сумын 101 цэгт хийж гүйцэтгэдэг. Хугацаа болоогүй.	100
23.	Арга хэмжээ 5.5. Гадаргын ус судлал (ГУС)-	Улсын төсөв	Шинжилгээний ажлын дундаж	Сүүлийн 3 жилийн шинжилгээний ажлын	Дундаж дүн 98.5%	06 дугаар сарын 05-ны байдлаар Шинжилгээний	100%

1	2	3	4	5	6	7	8
	ын шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх.		дүн, %	дундаж дүн 98.5 %		ажлын дундаж дүн 100 %	
24.	Арга хэмжээ 5.6. Орчны хяналт шинжилгээний ажлыг хөтөлбөрийн дагуу хийх.	Улсын төсөв	Шинжилгээний ажлын нэгдсэн дүн, %	Сүүлийн 3 жилийн шинжилгээний ажлын нэгдсэн дүн 99.7%	Шинжилгээний ажлын нэгдсэн дүн 99.7%	06 дугаар сарын 05-ны байдлаар хөтөлбөрийн биелэлт 100%, агаарын чанарын хоногийн мэдээ, усны чанарын мэдээ бүрэн дамжуулсан ирц 100%.	100%
25.	Арга хэмжээ 5.7. Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэлийн тооллогыг нутгийн захиргааны байгууллагуудтай хамтран аймгийн хэмжээнд зохион байгуулах	Улсын төсөв	Эх үүсвэрийн тооллогод хамрагдсан сумын тоо	Агаарын бохирдлын эх үүсвэрийн тооллогыг 19 суманд зохион байгуулсан.	19	2025 оны Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тооллогыг журмын дагуу 19 суманд зохион байгуулж, ажлын хэсэг байгуулан ажиллав. Тооллогын дүн мэдээг журмын хавсралт 6, 7 дугаар маягтын дагуу нэгтгэн, 2026 оны 03 дугаар сарын 15-ны дотор аймгийн ЗДТГ болон Цаг уур, орчны шинжилгээний газрын Орчны шинжилгээний хэлтэст хугацаанд нь хүргүүлсэн.	100%
26.	Арга хэмжээ 5.8. Шинжилгээний архивын ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх	Улсын төсөв	Шинжилгээний архив, мэдээллийн дэд сангийн дүнгийн Дундаж, хувиар	Сүүлийн 3 жилийн дундаж 99.88%	Дундаж 99.9%	Шинжилгээний архив-99,9% мэдээллийн дэд сангийн -99,9%	99,9%
Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт							
27.	Зорилт 6. Архив, албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомж, стандарт мөрдүүлэх ажлыг зохион байгуулах	Улсын төсөв	Зохион байгуулсан сургалтын тоо	2025 онд архив, албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомж, стандартын талаар танхимаар 2 удаа, цахимаар 2 удаагийн сургалт зохион байгуулсан.	2 болон түүнээс дээш удаа сургалт зохион байгуулсан байна.	2026 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн сургалт мэдээллийн цагаар Архив, албан хэрэг хөтлөлтийн хууль, Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын онцлох заалтуудын талаар 1 удаагийн сургалт зохион байгууллаа.	100
28.	Арга хэмжээ 6.1. Албан хаагчдыг албан хэрэг	Улсын төсөв	Сургалтын тоо	2025 онд архив, албан хэрэг хөтлөлтийн хууль	Архив, албан хэрэг хөтлөлтийн	Архивын ерөнхий газрын сургалтын төлөвлөгөөний дагуу	100

1	2	3	4	5	6	7	8
	хөтлөлтийн журам, стандартын сургалтад хамруулах ажлыг зохион байгуулах			тогтоомж, стандартын талаар танхимаар 1 удаа, цахимаар 1 удаагийн сургалт зохион байгуулсан. Танхимд 4, цахимд 11, нийт 15 албан хаагч хамрагдсан.	чиглэлээр тус бүр 2 болон түүнээс дээш удаа сургалтад хамруулсан байна.	“Албан хэрэг хөтлөлт, архивын ажилтан”-ы мэргэжлээр нярав, байгууллагын архивын ажилтан сургалтад хамруулсан. (Хувийн зардлаар суралцсан.)	
29.	Арга хэмжээ 6.2. Байгууллагын архивт нөхөн бүрдүүлэлт хийх ажлыг зохион байгуулах.	Улсын төсөв	Цаасан суурьтай болон цахим баримтын нэр, төрлийн тоо	Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2024 оны 22 нэр төрлийн 3136 хуудас баримтыг байгууллагын архивт хүлээн авсан.	-Цаасан суурьтай баримт 48 нэр төрөл, Цахим баримт 53 нэр төрөл хүлээн авсан байна.	Ерөнхий нягтлан бодогчоос цаасан суурьтай 27 хн, Бичиг хэрэг, хүний нөөцөөс 22 хн, Ерөнхий технологич инженер 5хн, Урьдчилан мэдээлэхийн технологич инженер 1 хн, нярав 2 хн нийт 57 хн хүлээн авсан. Цахим баримт нийт 44 хэмжээ 4264,21 mb баримт нягтлан шалгалт хийж хүлээн авсан.	
30.	Арга хэмжээ 6.3. Байгууллага, албан тушаалтанд ирсэн өргөдөл, гомдол, хариутай бичгийн шийдвэрлэлтийн тайлан мэдээ гаргах, холбогдох газарт хүргэх	Улсын төсөв	-Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээний тоо -Ирсэн хариутай бичгийн шийдвэрлэлт, %	Жилийн эцсийн байдлаар хариутай 97 баримт бичгийг хяналтын хугацаанд бүрэн шийдвэрлэсэн. Байгууллага дотроо шийдвэрлүүлэх 57 хүсэлтийг бүрэн шийдвэрлэсэн. Аймгийн Засаг даргын Тамгын газарт 4 улирлын өргөдөл гомдлын тайланг холбогдох маягтаар гаргаж хүргүүлсэн.	-11 удаа төвийн даргад -4 удаа ЗДТГ-т тайлан хүргүүлсэн байна. -Хариутай бичгийн шийдвэрлэлт 100%	-4 удаа төвийн даргад -Тайлан мэдээний журам шинэчлэгдсэнээр ЗДТГ-руу мэдээг хүргүүлэхгүй болсон тул 1 удаа шийдвэрлэлтийн мэдээ гаргаж, ил тодын самбар болон сайтад байршуулсан. -2026 оны 05 дугаар сарын 31-ний байдлаар 57 хариутай бичгийн шийдвэрлэлт 100%	100
31.	Зорилт 7. Мэдээллийн ил тод байдлыг хангах	Улсын төсөв	Холбогдох цахим сайтад байршуулсан мэдээ,%	Архангай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв” пэйж хуудас болон https://shilen.gov.mn 33 нэр төрлийн мэдээг	100%	Нийтийн ил тод мэдээллийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган arkhangai.namem.gov.mn, shilen.gov.mn сайтуудад	100%

1	2	3	4	5	6	7	8
				100% байршуулсан.		холбогдох мэдээллийг тухай бүр байршуулсан. 2026 оны 06 дугаар сарын 04-ний байдлаар нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн шалгуур үзүүлэлтүүдийн дагуу 2 дугаар улирлын тайланг өөрийн байгууллагад хамаарах мэдээллийг байршуулах ажил 85 хувийн явцтай байна.	
32.	Арга хэмжээ 7.1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах	Улсын төсөв	Олон нийтэд нээлттэй байршуулсан мэдээлэл,% Нэр төрөл, тоогоор	33 нэр, төрлийн мэдээг 100% байршуулсан.	28 нэр төрлийн мэдээг 100% байршуулна.	2026 оны 01 дүгээр улиралд 28 нэр төрлийн мэдээг 100% байршуулсан. 97% хувьтай үнэлэгдсэн. 2026 оны 06 дугаар сарын 04-ний байдлаар 2 дугаар улирлын тайланг 28 нэр, төрлийн мэдээг байршуулах ажил 85 хувийн явцтай байна.	100%
33.	Арга хэмжээ 7.2. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах	Улсын төсөв	-Шилэн дансанд байршуулсан мэдээ,% -Тайлан, тоогоор	-2025 онд Шилэн дансан (https://shilendans.gov.mn)-д байршуулсан мэдээ 100% . -4 тайлан илгээсэн.	-Шилэн дансанд байршуулсан мэдээ,100% -Тайлан 4	2026 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн байдлаар 55 мэдээг 100% хуулийн хугацаанд байршуулж, улирлын тайлан 2 удаа илгээсэн.	100%
34.	Арга хэмжээ 7.3. Архангай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв” пэйж хуудсанд мэдээ байршуулах	Улсын төсөв	Байршуулсан мэдээ, мэдээллийн тоо	Мэдээлэл үйлчилгээний чиглэлээр 3, мэргэжлээ сурталчилсан сургалт, үйл ажиллагааны 7, байгууллагын бусад үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээлэл 12, Нийт 22 мэдээ байршуулсан.	48 болон түүнээс дээш мэдээ , мэдээлэл байршуулсан байна.	Мэдээлэл үйлчилгээний чиглэлээр 70 гаруй, мэргэжлээ сурталчилсан сургалт, үйл ажиллагааны 7, байгууллагын бусад үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээлэл 30, Нийт 90 гаруй мэдээ байршуулсан.	100%
35.	Зорилт 8. Байгууллагын санхүү,	Улсын төсөв	Холбогдох хуулийн	2025 онд 2,618,328.5 мянган төгрөгийн төсөв	100 %	2026 оны 4 дүгээр сарын байдлаар 758,705.3 мянган	100%

1	2	3	4	5	6	7	8
	нягтлан бодох бүртгэл, төсвийн удирдлага болон гүйцэтгэлийг хэрэгжүүлж батлагдсан төсвийг үр ашигтай удирдах.		хэрэгжилт, %	батлагдаж гүйцэтгэлээр 2,560,223.3 мянган төгрөгийг зарцуулсан. Нэмэлт санхүүжилтын дансаар аймгийн Засаг даргын Тамгын газраас 97,852.0 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан. Холбогдох хуулийн хэрэгжилт 100 %		төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 736,735.9 мянган төгрөгийг зарцуулсан. Нэмэлт санхүүжилтын дансаар 2025 оны үйл ажиллагааны давсан орлого болох 89.2 мянган төгрөгийг авч зарцуулсан. Холбогдох хуулийн хэрэгжилт 100%	
36.	Арга хэмжээ 8.1. Санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС) болон үндэсний стандартын дагуу хугацаанд нь үнэн зөв, гаргаж холбогдох газруудад хүргүүлэх.	Улсын төсөв	Тайлангийн тоо	2	1	2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2026 оны 01 дүгээр сарын 24-ны өдөр Сангийн яамны Е-Тайлан болон https://finperform.mof.gov.mn цахим системд шивж илгээн, Архангай аймаг дахь Төрийн аудитын газраар баталгаажуулан “Өөрчлөлтгүй” дүгнэлт авч, 2026 оны 02 дугаар сарын 12-13-ны өдөр ЦУОШГ-ын нэгдсэн тайланд нэгтгүүлсэн.	100%
37.	Арга хэмжээ 8.2. Татвар, нийгмийн даатгалын тайланг гаргах	Улсын төсөв	Тайлангийн төрөл, тоо	-Татварын тайлан- 4 -Нийгмийн даатгалын тайлан-12	-Татварын тайлан 2 -Нийгмийн даатгалын тайлан - 6	-2025 оны 4, 2026 оны 1 дүгээр улирлын татварын тайланг хуулийн хугацаанд тайлагнасан. -2025 оны 12, 2026 оны 01-04 дүгээр сарын нийгмийн даатгалын тайланг хуулийн хугацаанд тайлагнаж баталгаажуулсан.	100%

1	2	3	4	5	6	7	8
38.	Арга хэмжээ 8.3. Байгууллагын өмч, хөрөнгийн тооллогыг зохион байгуулах	Улсын төсөв	-Тооллого явуулсан тоо	2	1	Эхний хагас жилийн байгууллагын өмч хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг Төвийн даргын 05 дугаар сарын 29-ний өдрийн А/37 дугаар тушаалаар 9 хүний бүрэлдэхүүнтэй комисс байгуулан, 06 дугаар сарын 01-ний өдрөөс 07 дугаар сарын 09-ний өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулан ажиллаж байна.	100
39.	Зорилт 9. Хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, удирдах дээд байгууллагын шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнах	Улсын төсөв	-Хэрэгжилтийн тайлан, тоогоор	Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2025 оны А/162 дугаар тушаалын дагуу бүтэц, орон тооны өөрчлөлтийг 09 дүгээр сард багтаан зохион байгуулсан. Цаг уур, орчны шинжилгээний газрын шуурхай үүрэг даалгаврын биелэлтийг 4 удаа гаргаж, аймгийн Засаг даргын Тамгын газрын шуурхай үүрэг даалгаврыг 11 удаа гаргаж хүргүүлсэн. Тайлан 2 удаа гаргаж хүргүүлсэн.	Хэрэгжилтийн тайлан 2 Жилд 2 удаа тайлагнана.	Байгууллагад хамраалтай Хууль тогтоомж, тогтоол, ҮАБЗөвлөлийн тэмдэглэл, Засгийн газрын тогтоол, ЗГХТэмдэглэл, Ерөнхий сайдын албан даалгаварын нийт 77 арга хэмжээнээс Хасуулах саналтай 4, төсөв санхүүгийн хүрэлцээгүйгээс биелэлт гаргах боломжгүй 3 арга хэмжээ байв. Нийт 70 арга хэмжээний биелэлийг гарган хүргүүлээ.	100%
40.	Арга хэмжээ 9.1. Албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх ажлыг зохион байгуулах	Улсын төсөв	-Үнэлгээ хийсэн тоо	Албан хаагчдын 2025 оны ажлын гүйцэтгэл, үрд дүнг холбогдох журмын дагуу жилд 2 удаа үнэлж, урамшуулах ажлыг зохион байгуулсан.	2	II , IV хугацаа болоогүй.	Үнэлгэ эний баг

1	2	3	4	5	6	7	8
41.	Арга хэмжээ 9.2 . Байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулах, тайлагнах	Улсын төсөв	-Төлөвлөгөө, тоо -тайлан, тоо	-	-Төлөвлөгөө 1 -Тайлан 2	Байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2026 оны 02 дугаар сарын 04-ний өдөр баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийн хагас жилийн тайланг 2026 оны 06 дугаар сарын 04-ний өдөр нэгтгэн боловсруулсан.	100%
42.	Арга хэмжээ 9.3. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалтнуудын 2025 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг өгөх	Улсын төсөв	Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг өгсөн албан тушаалтны тоо	2	2	Байгууллагын дарга болон ерөнхий нягтлан бодогч 2025 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэгээ 2026 оны 02 дугаар сард хуулийн хугацаанд гаргаж холбогдох газарт хүргүүлсэн.	100%
43.	Арга хэмжээ 9.4. Төрийн албан хаагч ёс зүйтэй ажиллахад дэмжлэг үзүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг идэвхжүүлэх	Улсын төсөв	-Арга хэмжээний тоо -Сургалтын тоо	Соён гэгээрүүлэх 2 арга хэмжээ, 1 сургалтыг тус тус зохион байгуулсан.	-Арга хэмжээ 4 -Сургалт 2 зохион байгуулна.	Бүтэн жилийн хугацаанд 4 арга хэмжээ төлөвлөснөөс Аймгийн Насан туршийн суралцахуйн төвтэй хамтран албан хаагчдын хандлага, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор “Сэтгэлгээний өөрчлөлт” сэдэвт багц сургалтыг 4 удаа, “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалтыг 5 удаагийн сургалтад тус тус хамрагдав. Төвийн нэгдсэн сургалтын үеэр төрийн албан хаагчдын ёс зүйн эрсдэлд өртөх магадлалын судалгааны дүнг танилцуулж, харилцаа, хандлагын нийтлэг алдаа дутагдлыг арилгах асуудлаар мэдээлэл хийлээ.	Ёс зүйн дэд хороо

1	2	3	4	5	6	7	8
						Мөн “Бие биедээ үлгэрлээ, өөрчилъе” уриан дор нөлөөллийн ажлыг эрчимжүүлж, ёс зүйн соёлыг төлөвшүүлэх чиглэлээр албан хаагчдад чиглэл өглөө.	
44.	Арга хэмжээ 9.5. Байгууллагын Ёс зүйн дэд хороо (ЁЗДХ)-ны жилийн ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлж, тайлагнах	-	-Хамт олонд тайлагнасан тоо	Жилд 1	Жилд 2	II, IV тайлагнах хугацаа болоогүй.	ЁЗДХ
45.	Арга хэмжээ 9.6. “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, технологи шинэчлэлийн жил” –ийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлан гаргах	Улсын төсөв	Байгууллагад хамаарах арга хэмжээний хэрэгжилтийн тайлан, тоогоор	-	Хагас, бүтэн жилээр тайлагнана. -Тайлангийн тоо 2	“Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, технологи шинэчлэлийн жил” –ийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу байгууллагад хамаарах арга хэмжээний хэрэгжилтийн тайланг 2026 оны 06 сарын 05-нд Цаг уур орчны шинжилгээний газрын Технологи, инновацын хэлтэст хүргүүлсэн.	
46.	Арга хэмжээ 9.7. Байгууллагын мэдээлэл үйлчилгээний ажлын талаар иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авах	Улсын төсөв	Судалгааны давтамж	1 удаа	Жилд 2 удаа	Байгууллагын цахим системээр дамжуулан сэтгэл ханамжийн судалгааг авах ажлыг зохион байгуулсан.	Үнэлгэ эний баг
Биелэлт		9 зорилт, 41 арга хэмжээ					???

Товчилсон нэрийн тайлал :

ЕТИ	Ерөнхий технологич инженер
ЕНБ	Ерөнхий нягтлан бодогч
ГУС	Гадаргын ус судлал
ХААЦУ	Хөдөө аж ахуйн цаг уур
ЦУУА	Цаг уур, уур амьсгал
БОШЛ	Байгаль орчны шинжилгээний лаборатори
УМТИ	Урьдчилан мэдээлэхийн технологич инженер

ЦУТИ	Цаг уурын технологич инженер
ХААЦУТИ	Хөдөө аж ахуйн технологич инженер
УСТИ	Ус судлалын технологич инженер
БОШЛТИ	Байгаль орчны шинжилгээний лабораторийн технологич инженер
ХСЕИ	Холбоо, сүлжээний ерөнхий инженер
МДСЕЗ	Мэдээллийн дэд сангийн ерөнхий зохицуулагч
ЦАЗНЕИ	Цаг агаарт зориудаар нөлөөлөхийн ерөнхий инженер
БНШК	Баримт нягтлан шалгах комисс
ӨХБЗ	Өмч хамгаалах байнгын зөвлөл
ХАБЭАЗ	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл
ЁЗДХ	Ёс зүйн дэд хороо

ТАЙЛАНГ ХЯНАСАН:
ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГА

Төсвийн төвлөрүүлэн захирагч

Э.БАТТУЛГА

. . . оны . . . дугаар сарын . . .

ХЭРЭГЖИЛТ ТАЙЛАГНАСАН:
АРХАНГАЙ АЙМГИЙН УС, ЦАГ УУР,
ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
ДАРГА

Төсвийн шууд захирагч

Б.БУЛГАНБААТАР

. . . оны . . . дугаар сарын . . .

АРХАНГАЙ АЙМГИЙН УС, ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН АЛБАН ХААГЧДЫН
СУРГАЛТЫН ХЭРЭГЦЭЭГ ХАНГАХ 2026 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

№	Сургалтын чиглэл	Сургалтад оролцогчид	Сургалтын хугацаа	Хугацаа, хоногоор	Сургалтад хамрагдах ажилтны тоо	Сургалтын хэлбэр	Хэрэгжилт
1	2	3	4	5	6	7	8
Нэг. Ажлын байран дахь сургалт							
1.	Архивын ерөнхий газраас зохион байгуулах албан хэрэг хөтлөлтийн цахим сургалтад албан хаагчдыг хамруулах	Байгууллагын бичиг хэрэг, архивын ажилтан	Архивын ерөнхий газрын баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу	Хөтөлбөрт заасан хугацаагаар	2	Цахим	Архивын ерөнхий газрын сургалтын төлөвлөгөөний дагуу “Албан хэрэг хөтлөлт, архивын ажилтан” бэлтгэх нэг сарын танхимын сургалтад нэг албан хаагчийг хамруулж, суралцах нөхцөл боломжоор хангасан. Төлөвлөгөөнд тусгагдсан өөр нэг албан хаагч оролцох байсан боловч ажлын зайлшгүй шаардлагаар сургалтад хамрагдах хугацааг хойшлуулсан.
2.	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх	Ус, цаг уурын өртөө, харуулын ээлжийн техникч, харуулын ажиглагч нар болон бусад ажилтан	Тухай бүр	Төлөвлөсөн хугацаагаар	62	Танхим болон цахим	2026 оны 06 дугаар сарын 04-ний байдлаар Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх сургалтыг танхим болон цахимаар нийт 4 удаа тус тус зохион байгуулав. Сургалтад хамрагдсан ажилтны тоо: Цахимаар- 36 Танхимаар-26 Давхардсан тоогоор 248 албан хаагч нарт сургалт болон зааварчилгаа өгсөн байна.
3.	Чиглүүлэх болон дадлагажуулах сургалт	Шинээр ажилд орж байгаа болон шилжин ажиллаж байгаа ажилтан	Тухай бүр	5-10	Гүйцэтгэлээр	Танхим	Чиглүүлэх болон дадлагажуулах сургалт зохион байгуулах нөхцөл бүрдээгүй.

1	2	3	4	5	6	7	8
4.	Албан хэрэг хөтлөлтийн хууль, журам, стандартын талаар албан хаагчдад сургалт зохион байгуулах	Байгууллагын албан хаагчид	01 дүгээр сард	8 цаг	60	Танхим болон цахим	2026 оны 01 дүгээр сарын 28, 03 дугаар сарын 06-ны өдрүүдийн сургалт мэдээллийн цагаар Архив, албан хэрэг хөтлөлтийн хууль, Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, стандартын онцлох заалтуудыг албан хаагчдад танилцууллаа. Сургалтад нийт 44 албан хаагч хамрагдсан. Цахимаар 19, танхимаар 25
5.	Насан туршийн суралцахуйн төвийн багц сургалтад хамрагдах	Байгууллагын нийт ажилтан, албан хаагчид	01 дүгээр улиралд Сэтгэлгээний өөрчлөлт	8 цаг	27	Танхим болон цахим	2026 оны 05 дугаар сарын 01-ний байдлаар “Сэтгэлгээний өөрчлөлт” сэдэвт багц сургалтыг 4 удаагийн сургалтад 12 албан хаагч, “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалтын 1 удаагийн сургалтад 41, үлдсэн сургалтуудад 10-12 албан хаагч тогтмол хамрагдсан. Багц сургалтыг цахимаар зохион байгуулах боломжгүй хэмээн тайлбарласан.
			02 дугаар улиралд: Төрийн албан хаагчийн ёс зүй	4 цаг	27		
Хоёр. Мэргэшүүлэх сургалт							
6.	Мэргэжлийн чиглэлээр сургалт зохион байгуулах	Сумдын ус, цаг уурын өртөө, харуулын инженер, ажиглагч, техникч нар	04 дүгээр сард	2	42	Танхим болон цахим	03 дугаар сарын 19-20-ны өдрүүдэд сургалт зохион байгуулсан. Ус, цаг уурын өртөө, харуулын 26 ажилтан оролцлоо. Мөн сумдын ус, цаг уурын өртөө, харуулд цахимаар 2 удаа , усны салбар 2 удаа танхимаар 1 удаа мэргэжлийн чиглэлээр сургалт зохион байгуулсан.
7.	Нислэгт цаг агаарын урьдчилсан мэдээгээр үйлчлэх эрх олгох сургалт	Урьдчилан мэдээлэхийн инженер	4 сард	10	1	Танхим	04 дүгээр сард болох сургалт 06 сард болж хойшлогдсон.
8.	Байгаль орчны шинжилгээний лабораторийн MNS ISO/IEC 17025:2018 стандарт эзэмшүүлэх	БОШЛ-ийн инженер	Эхний хагас жил	3	1	Танхим	БОШЛ-ийн инженерийг мэргэжлийн сургалтад хамруулах шаардлагатай боловч сургалтын төлбөрийн асуудал одоогоор шийдвэрлэгдээгүй байна.

1	2	3	4	5	6	7	8
	сургалтад хамруулах						
Гурав. ЦУОШГ-ын сургалтын төлөвлөгөөний дагуу зохион байгуулах сургалтад оролцох							
9.	Удирдах ажилтны сургалт, семинар	Төвийн дарга	2 сард	2	1	Танхим	2026 оны 02 дугаар сарын 26, 27-ны өдрүүдэд Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэх уулзалтад оролцсон.
10.	Уур амьсгалын инженерүүдийг чадавхжуулах сургалт	Цаг уурын технологич инженер	6 сард	3	1	Танхим	Төсөв санхүү шийдэгдээгүй учир сургалтын хугацаа тодорхойгүй. Үнэлэх боломжгүй.
11.	"Монголын өгөгдлийн шоо" системийг ашиглах цахим сургалт	Төвийн болон сумдын албан хаагчид	4, 9 сард	2	оролцоогоор	Цахим	Сургалт зохион багуулагдаагүй хойшлогдсон.
12.	Ус судлалын харуулын ажиглагчийн сургалт	Ус судлалын харуулын ажиглагч	10 сард	21	1	Танхим	Сургалтын хугацаа болоогүй
13.	Ус судлалын инженерүүдийг чадавхжуулах сургалт	Ус судлалын инженер	6 сард	5	1	Танхим	Сургалтын хугацаа болоогүй
14.	ЦАЗН-үйл ажиллагааны эрхийн сургалт	ЦАЗН-ын ерөнхий инженер, урьдчилан мэдээлэхийн технологич инженер	3 сард	5	2	Танхим	2026 оны 03 дугаар сарын 16-нд Цаг агаарт зориудаар нөлөөлөхийн инженер Г.Ууганзаяа, экспедицийн синоптик инженер С.Мөнхтөр нар "Тэсэрч дэлбэрэх бодис , тэслэгээний аюулгүй байдал" сэдэв сургалтад хамрагдаж, эрхийн үнэмлэх авсан.

1	2	3	4	5	6	7	8
15.	Агаарын чанарын MAMIS программын сургалт (чадавхжуулах)	БОШЛ-ийн инженер	2 сард	1	2	Цахим	Цаг уур, орчны шинжилгээний газар-ын Орчны шинжилгээний хэлтсээс 2026 оны 03 дугаар сарын 04-ний өдөр MAMIS систем болон агаарын чанарын багаж, тоног төхөөрөмжийн ашиглалтын чиглэлээр цахим сургалт зохион байгууллаа. Тус сургалтад БОШЛ-ийн 2 албан хаагч хамрагдав.
16.	Агаарын чанарын багаж төхөөрөмжтэй ажиллах (чадавхжуулах)	БОШЛ-ийн инженер	3 сард	-	1	Танхим	Цаг уур, орчны шинжилгээний газар-ын Орчны шинжилгээний хэлтсээс 2026 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр агаарын чанарын автомат станцын үйл ажиллагааны чиглэлээр цахим сургалт зохион байгууллаа. Сургалтыг БНСУ-ын мэргэжилтнүүд болон ОШХ-ийн ахлах мэргэжилтэн С.Энхмаа нар удирдан явуулсан бөгөөд тус сургалтад БОШЛ-ийн 2 албан хаагч хамрагдав.
17.	Орчны шинжилгээний мэдээлэл, үйлчилгээний чанарыг сайжруулах	БОШЛ-ийн албан хаагчид	4 сард	1	2	Цахим	Цаг уур, орчны шинжилгээний газар-ын Орчны шинжилгээний хэлтсээс 2026 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр MAMIS систем болон агаарын чанарын багаж, төхөөрөмжтэй холбоотой тулгамдсан асуудлуудаар цахим сургалт, зөвлөгөөнийг зохион байгууллаа. Аймаг бүрээс тулгарч буй асуудлуудыг PowerPoint хэлбэрээр асуулт болгон бэлтгэн хүргүүлсэн бөгөөд асуулт тус бүрт БНСУ-ын мэргэжилтнүүд болон ОШХ-ийн мэргэжилтэн С.Энхмаа нар мэргэжил, арга зүйн зааварчилгаа өгч ажиллав. Тус сургалтад БОШЛ-ийн 2 албан хаагч хамрагдав.
18.	Салбарын IT инженерүүдийг чадавхжуулах сургалт	Холбоо, сүлжээний ерөнхий инженер	9 сард	3	1	Танхим	Сургалтын хугацаа болоогүй.
19.	Нислэгт цаг агаарын урьдчилсан мэдээгээр үйлчилдэг Урьдчилан мэдээлэхийн инженерүүдэд	Урьдчилан мэдээлэхийн технологич инженер	5 сард	5	1	Танхим	05 дугаар сарын 25-29-ны өдрүүдэд НЦУТ-д танхимаар урьдчилан мэдээлэхийн инженер П.Чанцалдулам тус сургалтад оролцсон.

1	2	3	4	5	6	7	8
	зориулсан давтан сургалт						
20.	Ёс зүйн зөрчлөөс ангид байх, соён гэгээрүүлэх сургалт	Төвийн болон сумдын албан хаагчид	4, 6, 9 сард	4 цаг	оролцоогоор	Цахим	2026 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн ЦУОШГ-ын Ёс зүйн дэд хорооноос зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн ойлголт, хэрэглээ” сэдэвт цахим сургалтад албан хаагчдыг оролцууллаа. 20 албан хаагч хамрагдсан.
21.	Салбарын хууль тогтоомж, эрх зүйн актуудын талаарх мэдлэг олгох сургалт	Төвийн болон сумдын албан хаагчид	3, 6, 9 сард	3 цаг	оролцоогоор	Цахим	ЗГХХГ болон СХЗГ-уудтай хамтран MNS7068:2025 “Төрийн албаны үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага” стандартын талаар зохион байгуулсан цахим сургалтад оролцлоо. Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн төслийн хэлэлцүүлэг болон бусад сургалт, мэдээллүүдэд 6 удаа оролцсон. Нийт 8 цагийн сургалтад хамрагдсан.
22.	Цахим ур чадварын сургалт	Төвийн болон сумдын албан хаагчид	3, 6, 9 сард	3 цаг	оролцоогоор	Цахим	2026 оны 03 дүгээр сарын 20-нд Төвийн албан хаагчдад цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулж, цахим хэрэглээ, мэдээллийн аюулгүй байдал, тоон технологийн хэрэглээний талаарх мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр мэдээлэл өгч ажилласан.
23.	АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс, Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэстэй хамтран зохион байгуулах сургалтад оролцох	Төвийн болон сумдын албан хаагчид	эхний хагас жил, сүүлийн хагас жилд	2 цаг	оролцоогоор	Цахим	2026 оны 04 дүгээр сарын 21-нд Насан туршийн суралцахуйн төвтэй хамтран албан хаагчдаа “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-д заасан хориглолт, хязгаарлалт, анхаарах асуудлын талаар “Авлигын гэмт хэргийн нийгмийн хор аюул, хохирол” сэдвээр 1 цагийн сургалтад хамрууллаа.

1	2	3	4	5	6	7	8
24.	“Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хуулийн хэрэгжилт, нээлттэй өгөдлийн нэгдсэн систем /shilen.gov.mn/-д оруулсан мэдээллийн талаар чиглүүлэх сургалт	Холбоо, сүлжээний ерөнхий инженер	3, 6, 9, 12 сард	4 цаг	1	Цахим	Цаг уур, орчны шинжилгээний газраас ирсэн “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хуулийн хэрэгжилт, нээлттэй өгөдлийн нэгдсэн систем /shilen.gov.mn/-д оруулсан мэдээллийн талаар чиглүүлэх зөвлөмжийн дагуу 2026 оны 03 дугаар сарын 12-нд https://arkhangai.namem.gov.mn/ -д мэдээлэл байршуулж зөвлөмжийн биелэлтийг Цаг уур, орчны шинжилгээний газарт албан бичгээр хүргүүлсэн. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас цахимаар 2026 оны 03 дугаар сарын 22-нд “shilen.gov.mn”-ийн 2.0 хувилбарын сургалтанд Байгууллагын мэдээлэл хариуцсан ажилтан хамрагдсан.
25.	Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу шөнийн цагийн нэмэгдэл хөлс олгох, дундаж цалин тооцох, илүү цаг зэрэг цалин хөлстэй холбоотой журам, аргачлалын талаар сургалтад хамрагдах	Төвийн болон сумдын албан хаагчид	Жилдээ	4 цаг	оролцоогоор	Цахим	2026 оны 0 дугаар сарын 31-ний байдлаар зохион байгуулагдаагүй.
Дөрөв. Туршлага солилцох арга хэмжээ болон бусад чиглэлээр							
26.	Аймгийн ЗДТГ, бусад төрийн болон төрийн бус байгууллага, төсөл хөтөлбөрийн сургалтад хамрагдах	Холбогдох албан хаагч	Тухай бүр	Тухайн сургалтын хугацаагаар	Гүйцэтгэлээр	Танхим болон цахимаар	2026.01.13-ны өдөр “Үндсэн хууль ба хүний эрх сэдэвт танхимын сургалтад 10, 2026.01.16-нд “Авлигын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх цахим сургалтад 2, “2026.01.31-нд УИХ-ын дарга Н.Учралын уулзалтад 5, Үр дүнд суурилсан бодлого төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ” сэдэвт цахим сургалтад 5,

1	2	3	4	5	6	7	8
							2026.02.27-ны өдрийн ЗГХХГ-аас зохион байгуулсан “Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн талаарх 2 цагийн цахим сургалтад 1, 2026.03.13-нд газрын тухай хуулийн хэлэлцүүлэгт 2, 2026.03.19-ний өдрийн Канадын ЗГ-ын санхүүжилттэй “Тэгш хүртээмжтэй засаглалын төлөө бүтээлч манлайлал (i-lead) төслийн “Хувь хүний өгөгдөл хамгаалал, байгууллагын мэдээллийн аюулгүй байдал” танхимын сургалтад 1, 2026.03.22-ны өдрийн “Эцэг эхийн хурал”-д 2, 2026.04.08-ны өдрийн “Төрийн болон албаны нууц хамгаалах” чиглэлээр зохион байгуулсан сургалтад 1, 2026.04.20-21-ны өдрүүдэд зохион байгуулсан “Төрийн захиргааны албан хаагчдын зөвлөгөөн”-д 2, 2026.04.14-ны өдрийн И Монгол академи УТҮГ-с ERP-системийн цахим сургалтад 21, 2026.04.14-ний өдрийн Канадын ЗГ-ын санхүүжилттэй “Тэгш хүртээмжтэй засаглалын төлөө бүтээлч манлайлал (i-lead) төслийн “Мэдээллийн мессэж боловсруулах” танхимын сургалтад 1, 2026.04.16-ны өдрийн “Газрын тухай хууль болон ЗГ-ын 2020 оны 10 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах” танхимын сургалтад 2, 2026.04.28-ны өдрийн Канад-Монголын Мерит төслийн техникийн Сюзан Ингрэмийн “ИРгэн төвтэй төрийн үйлчилгээ үзүүлэх шинэ арга барил” сэдэвт танхимын сургалтад 1, 2026.05.14-ний “Ажлын байрны эрүүл ахуй, сэргээгдэх эрчим хүчний талаар мэдлэг олгох”

1	2	3	4	5	6	7	8
							танхимын сургалтад 1 албан хаагч тус тус оролцов. ТАЗ-ийн 7:4:10 сургалт мэдээллийн 4 удаагийн сургалтад албан хаагчдыг хамрууллаа.
27.	“Сургалт, мэдээллийн цаг”-т тодорхой сэдвээр сургалт зохион байгуулах	Байгууллагын албан хаагчид	Сар бүр	1-2 удаа	63	Танхим болон цахим	11 удаагийн сургалт, мэдээллийг танхим болон цахимаар зохион байгууллаа. Сэдэв: Гүйцэтгэлийн төлөвлөгөө төлөвлөхөд анхаарах асуудлууд, төрийн албан хаагчдын хувийн хэрэг хөтлөх журам, анхаарах асуудлууд, ERP систем ашиглалт, тоон гарын үсэг хэрэглээ, цаг агаарын урьдчилсан мэдээ, зөвлөмж, ArcGis дээр ажиллахад анхаарах асуудлууд, байгууллагын төсвийн тухай, ТАЗ-ийн зөвлөгөөний мэдээлэл, Архив, албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомж, төрийн албаны стандарт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, цаг үеийн шуурхай мэдээ мэдээлэл зэрэг сэдвүүдийн хүрээнд зохион байгууллаа. Хамрагдсан албан хаагчийн тоо 45-50 төвийн албан хаагчид танхимаар, сумдын албан хаагчид цахимаар тус тус оролцлоо.

Товчилсон нэрийн тайлал :

ХАБЭАЗ	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл
ЦУОШГ	Цаг уур, орчны шинжилгээний газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЕТИ	Ерөнхий технологич инженер
ЕНБ	Ерөнхий нягтлан бодогч
УМТИ	Урьдчилан мэдээлэхийн технологич инженер
БОШЛТИ	Байгаль орчны шинжилгээний лабораторийн технологич инженер
ЦАЗН	Цаг агаарт зориудаар нөлөөлөх

Хавсралт №2.

АРХАНГАЙ АЙМГИЙН УС, ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН АЛБАН ХААГЧДЫН
НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ 2026 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

№	Хийх ажил	Хугацаа	Хэрэгжилт
1	2	3	4
Зорилт 1: Албан хаагчдын ажлын байрны орчин, нөхцөлийг сайжруулах зорилтын хүрээнд:			
1.	Ажлын байрны дотоод орчныг тохижуулж, эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх	Жилдээ	Ажлын байрны дасгал хийдэг.
2.	Албан хаагчдыг албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай орчин үеийн болон эрүүл ахуйн шаардлага хангахуйц компьютер, тоног төхөөрөмж, бичгийн хэрэгслийн хангалт, шинэчлэлийг тогтмол хийх;	Тухай бүр	Албан үүргээ гүйцэтгэх нөхцөлийг хангахаар урьдчилан мэдээлэх салбарын болон Төвшрүүлэх өртөөнд компьютерийн засвар үйлчилгээг хийж хэвийн ажиллуулав. Мөн 4 өртөөнд бичгийн цаасаар хангалт хийв.
Зорилт 2: Цалин хөлс, нэмэгдэл, шагнал урамшуулал, тэтгэвэр тэтгэмж, нөхөн төлбөр, тусламж дэмжлэгийг хуулийн хүрээнд үзүүлэх зорилтын хүрээнд:			
1.	Засгийн газраас баталсан албан тушаалын цалингийн сүлжээг баримтлан албан хаагчдын цалинг тухай бүр шинэчлэн тогтоож мөрдөх	Жилдээ	Засгийн газрын 2023 оны "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай" 240 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн үйлчилгээний мэргэжлийн бусад байгууллагын албан тушаалын зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт", 6 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт"-ыг тус тус мөрдөн ажиллаж байна.
2.	Албан тушаалын цалин, нэмэгдэл, суутгал, шимтгэл зэргийг тусгасан мэдээллийг сар бүр тухай албан хаагчид гаргаж өгөх	Жилдээ	Албан хаагчдын цалингийн мэдээллийг сар бүр албаны цахим хаягаар хүргүүлж байна.
3.	Албан хаагчдын цалинг ажилласан жилийг харгалзан нэмэгдүүлэх, мэргэшлийн зэрэг, ур чадварын нэмэгдлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу Засгийн газраас тогтоосон хувь хэмжээгээр олгох	Жилдээ	Мөрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг ажилласан жил тутамд тооцож, холбогдох мэдээллийг хүний нөөцийн системд оруулснаар албан хаагчдын цалин хөлс тухай бүр шинэчлэгдэж байна. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2023 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн А/421, А/115, А/170 дугаар хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэрэг олгох шалгуур үзүүлэлт, хэрэглэх журам"-ын 3 дугаар бүлгийн 3.7 дахь заалтын дагуу нэг албан хаагчийн мэргэшлийн 3 дугаар зэргийг 2026 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс үргэлжлүүлэн олгож байна.
4.	Төрийн алба хаасан хугацааг тодорхойлж, нэмэгдэл олгох, ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг жилд 2 удаа буюу хагас, бүтэн жилээр шийдвэрлэх	Хагас, бүтэн жилээр	1, 2 дугаар улирлын ур чадварын түвшинг үнэлгээний ажлын хэсэг үнэлж тус бүр 20 албан хаагчдад нийт 15,591.2 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон.
5.	Албан хаагчдын мэргэшлийн зэрэг олгох шалгалтыг зохион байгуулах	Жилдээ	Мэргэшлийн зэргийн салбар комисс 2026 оны 03 дугаар сарын 11-ний өдөр хуралдаж, шалгуур хангасан албан хаагчдын судалгааг гаргаж, хүсэлтийг хүлээн авч байна. Мэргэшлийн зэргийн шалгалтын товыг Цаг уур, орчны

1	2	3	4
			шинжилгээний газрын ажлын хэсгээс санал авсны үндсэн дээр тогтоож, зохион байгуулахаар шийдвэрлэв. 2026 оны 04 дүгээр сарын гүйцэтгэлээр 4,660.2 мянган төгрөг олгосон байна.
6.	Хоолны хөнгөлөлтийг байгууллагын дотоод журмын дагуу тухайн жилийн төсөвтэй уялдуулан олгох	Жилдээ	Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу батлагдсан цалингийн санд багтаан хоолны хөнгөлөлтийг орон нутгийн албан хаагчдад өдрийн 10,000 төгрөгөөр, аймгийн төвийн албан хаагчдад өдрийн 20,000 төгрөгөөр тус тус тооцон олгож байна. Эхний 4 сарын байдлаар 68,950.0 төгрөгийг олгоод байна.
7.	Хөдөлмөрийн хортой нөхцөл, шөнийн болон илүү цагаар ажилласан, орон нутагт ажилласны нэмэгдэл хөлсийг хууль тогтоомжид заасны дагуу олгох	Жилдээ	2026 оны 04 дүгээр сарын гүйцэтгэлээр хөдөлмөрийн хортой нөхцлийн нэмэгдэл 2 албан хаагчид 1,104.4 мянган төгрөг, шөнийн цаг, илүү цаг, нийтээр амрах баяр ёслолын цагийн нэмэгдэл хөлс 39 албан хаагчид 34,543.9 мянган төгрөг, орон нутагт ажилласны нэмэгдэл 63 албан хаагчид 102,527.5 мянган төгрөгийг тус тус холбогдох хууль тогтоомжийн дагуу тооцон олгоод байна.
8.	Орон нутагт томилолтоор ажиллах албан томилолтын зардлыг олгох	Тухай бүр	2026 оны төсөвт албан томилолтын зардал нийт 1,200.0 мянган төгрөг батлагдсан боловч 12 дугаар сарын төсвийн хуваарьт хуваарилагдсан. Сангийн яамнаас төсвийн хуваарьт өөрчлөлт оруулахгүй байгаа тул албан томилолтын зардал олгоогүй байна.
9.	Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний гүйцэтгэл, үр дүнд өгсөн үнэлгээ болон байгууллагын дотоод журмыг үндэслэн мөнгөн урамшууллыг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх, төрийн дээд шагнал одон, медаль, салбарын болон бусад байгууллагын шагналаар шагнах, гадаад, дотоод сургалтад хамруулах, мэргэшүүлэх зэргээр урамшуулах;	Хагас, бүрэн жилээр	Дэлхийн ус, цаг уурын өдөр болон аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн түүхт 90 жилийн ойг тохиолдуулан хамт олныхоо хөдөлмөр зүтгэлийг үнэлж, шагналын тодорхойлолтуудыг уламжиллаа. Тайлант хугацаанд төрийн дээд одон, медальд 27 ажилтныг дэвшүүлсэн бол Засгийн газар болон салбарын яамны шагналуудад 11 албан хаагчийг тодорхойлсон юм. Үүнээс Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны “Байгаль орчны тэргүүний ажилтан” тэмдгээр 8, салбарын “Жуух бичиг”-ээр 3 албан хаагч шагнагдсан.
10.	Төрийн албан хаагчийн ээлжийн амралтыг биеэр эдлүүлэх, ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй албан хаагчид хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ээлжийн амралтын цалинг нэг аравны тав дахин нэмэгдүүлж олгох	Жилдээ	Албан хаагчдын ээлжийн амралтын хуваарийг 01 дүгээр сард баталж мөрдөж ажиллаж байна.
11.	Албан хаагчдын нөхөн төлбөр, тэтгэмж, тусламж олгох зэрэг асуудлыг Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, холбогдох хууль тогтоомж болон байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-д заасны дагуу шийдвэрлэх;	Жилдээ	2026 оны төсөвт өндөр насны тэтгэвэрт гарах 2 албан хаагчийн тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн зардлыг 67,887.8 мянган төгрөгөөр тооцож хүргүүлсэн боловч 40 хувь буюу 27,155.1 мянган төгрөгийн төсөв батлагдсан.
Зорилт 3: Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалж, эрүүл амьдрах дадлыг хэвшүүлэх зорилтын хүрээнд:			

1	2	3	4
1.	Эрүүл мэндээ хамгаалах, төрөл бүрийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн мэдээ, мэдээллийн самбар болон цахим булан ажиллуулах	Жилдээ	2026 оны 05 дугаар сарын 07-ны өдөр 07 дугаар багийн ӨЭМТ-өөс САХАР-ын шинжилгээ болон урьдчилсан үзлэгт хамрагдав. Мөн 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдөр эрчүүдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамрууллаа.
2.	Хамт олны эерэг уур амьсгал бүрдүүлэх зорилгоор албан хаагчдыг хамруулсан нийгэм, соёл, спортын олон талт арга хэмжээг тогтмол зохион байгуулах, оролцуулах,	Жилдээ	03 дугаар сарын 20, 04 дүгээр сарын 17-ны өдрүүдэд хамт олны эерэг уур амьсгал бүрдүүлэх зорилгоор төв болон сумдын албан хаагчдын дунд гар бөмбөг, буухиа тэмцээн зохион байгуулж шалгарсан шилдгүүдийг урамшуулав. Мөн аймгийн Биеийн тамир, спортын газраас зохион байгуулж буй “Зөв гүйе”, “Өглөөний алхалт” зэрэг үйл ажиллагаанд албан хаагчдыг оролцох боломжоор хангалаа.
3.	Ажлын байранд дасгал, хөдөлгөөнийг хийлгэж хэвшүүлэх	Жилдээ	Ажлын байрны дасгал хөдөлгөөн хийж хэвшиж эхэлсэн. Спорт хорооноос зохион байгуулсан “Зөв гүйе” аянд идэвхтэй хамрагдсан. Эрүүл Монгол хүн үндсний хөдөлгөөний хүрээнд “Эрүүл мэндийн жим”-өглөөний алхалт аяны хүрээнд байгууллага хамт олноороо идэвхтэй хамрагдаж байна.
Зорилт 4. Албан хаагчдын амьдрах нөхцөлийг сайжруулах боломжийг судлах зорилтын хүрээнд:			
1.	Шинээр гэр бүл болж буй албан хаагчид хууль тогтоомжид заасан дэмжлэг үзүүлэх	Жилдээ	Эхний хагас жилийн байдлаар шинээр гэр бүл болсон албан хаагч байхгүй.
Зорилт 5. Төрийн албан хаагчийн нийгмийн хэрэгцээ, сэтгэл зүйн хандлагыг мэдэрч, байгууллагын соёл, хамт олны соёл, уур амьсгалыг өөрчлөх замаар албан хаагчдын ажлын байран дахь сэтгэл ханамжийг дээшлүүлэх			
1.	Албан хаагчийн үйл ажиллагаанд шаардагдах мэдээллийг тогтмол шуурхай дамжуулах, тэднийг мэдээллээр хангах зорилгоор 14 хоног бүр мэдээлэл, сургалтыг зохион байгуулж хэвших	Жилдээ	Нийт 11 удаагийн сургалт, мэдээллийн цагаар 22 төрлийн мэдээллийг танилцуулсан. Мөн ЦУОШГ-ын 8 сургалт, мэдээлэл, ТАЗ-ын 7:4:10-ын 6 цахим сургалтад оролцуулав.

Товчилсон нэрийн тайлал :

ЕТИ	Ерөнхий технологич инженер
ЕНБ	Ерөнхий нягтлан бодогч
УМТИ	Урьдчилан мэдээлэхийн технологич инженер

---oOo---